



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСААС БҮГД НАЙРАМДАХ
СИНГАПУР УЛСАД СУУГАА ОНЦ
БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД
Т.ЛХАГВАДОРЖ ТАНАА

2018.11.22 № 03/2357
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Элчин сайдын яамны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Сөрөг санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Элчин сайдын яамны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн/орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлээгүй гэж дүгнэн сөрөг санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Улсаас Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Элчин сайдын яамны 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

- Үнэт цаасыг бараа материалын дансанд бүртгээгүй, Сингапур долларыг Америк долларт шилжүүлж бүртгэхдээ Сингапур улсын Арилжааны банкны ханшаар хөрвүүлж санхүүгийн тайлан гаргасан;
- 2017 оны санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэл 2016 оны санхүүгийн тайлангийн эцсийн үлдэгдлээс 23.9 мянган ам.доллараар дутуу, машин, тоног төхөөрөмж, тавилга, аж ахуйн эд хогшил дансны эхний үлдэгдлийг хасах 20.7 мянга, эцсийн үлдэгдлийг хасах 24.6 мянган ам.доллараар буруу илэрхийлсэн;
- Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлээс 182.8 мянган ам.доллараар, эцсийн үлдэгдэл 186.7 мянган ам.доллараар тус тус зөрүүтэй, үндсэн хөрөнгийн тооллогын бүртгэлээс 358.6 мянган ам.доллараар дутуу илэрхийлсэн;
- Элчин сайдын 2016 оны А/02 дугаар тушаалаар Ю.Туяацэцэгийг нягтлан бодогчийн ажилд томилохдоо сар тутам 1024 ам.долларын цалин олгох тухай шийдвэр гаргасан нь Засгийн газрын 2001 оны 168, 2008 оны 336 дугаар тогтоолуудыг тус тус зөрчиж Дипломат төлөөлөгчийн газрын үйлчилгээ-техникийн ажилтны цалинг 40 хүртэл хувиар тогтоохоор заасан боловч 64 хувиар буюу 384 ам.доллараар илүү олгох шийдвэр гаргаж, 2018 оны 08 дугаар сарын байдлаар нийт 11.5 мянган ам.долларын цалинг илүү олгосон;
- Батлагдсан төсвийг нийт 71.4 мянган ам.доллараар хэтрүүлэн зарцуулсан, 2017 оны зарцуулагдаагүй үлдэгдэл болох 18.5 мянган ам.долларыг улсын төсөвт татан төвлөрүүлээгүй;
- Урьд оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 211.2 мянган ам.долларын зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлант онд зөрчлийг давтан гаргасан;
- Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 77 ажил, гүйлгээг мэдээлээгүй зэрэг алдаа, зөрчлүүд нь санхүүгийн тайлан бүхэлдээ буруу илэрхийлэгдэх эрсдэлийг үүсгэж, бидний тогтоосон материаллаг байдлаас 859.0 мянган ам.доллараар хэтэрч, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Эрх ба үүрэг”, “Оршин байх”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

УХА0122\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\1122SAG7.Docx

